

**“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН 2018 ОНЫ
02 ДУГААР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2018.03.02

Нэг. Зорилго

“ГТХЗНТ” УТУГ-ын бүтцийн нэгжүүдийн 2018 оны 02 дугаар сарын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаарх санал, зөвлөмжийг удирдлагад танилцуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх зорилготой.

Хоёр. Үндэслэл

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн болон бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан ажилтны 2018 оны ажлын төлөвлөгөөг үндэслэв.

Гурав. Төлөвлөгөөний хэрэгжилт

Хөдөлгөөн зохицуулалт, хөдлөх бүрэлдэхүүний хэлтэс 8, Технологи, мэдээлэл, сургалт, судалгааны хэлтэс 16, Захиргаа, санхүүгийн хэлтэс 19, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд нийт 43 ажлыг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Нэгжүүдийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд бүрэн хэрэгжсэн 30, хэрэгжих шатанд 8, хэрэгжилт хангалтгүй 2 арга хэмжээтэй, биелэлт **88,2** хувьтай байна.

| № | Нэгжийн нэр | Төлөвлөсөн ажлын тоо | Хэрэгжилтийн байдал /хувиар/ | | | | | Нэгжийн дүн |
|---|-------------|----------------------|---|---|--|--|---------------------------------------|-------------|
| | | | Бүрэн хэрэгжсэн 100 хувь (90-100 хүртэл хувь) | Хэрэгжих шатанд 70 хувь (50-89 хүртэл хувь) | Хэрэгжилт хангалтгүй 30 хувь (10-49 хүртэл хувь) | Хэрэгжээгүй 0 хувь (0-9 хүртэл хувь) | Хэрэгжилт ийг тооцох хугацаа болоогүй | |
| 1 | ХЗХБХ | 8 | 6 | 1 | 1 | - | - | 86,9 |
| 2 | ТМССХ | 16 | 11 | 3 | - | - | - | 88,0 |
| 3 | ЗСХ | 19 | 13 | 4 | 1 | - | - | 88,9 |
| | Дүн | 43 | 30 | 8 | 2 | - | - | 88,2 |

Дөрөв. Санал зөвлөмж:

Хөдөлгөөн зохицуулалт, хөдлөх бүрэлдэхүүний хэлтэст

1. Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2018 онд байгуулах үр дүнгийн гэрээний төслийн 1.1.1-д тусгагдсан “Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах санал боловсруулж, ЗТХЯ-нд хүргүүлэх” арга хэмжээний хүрээнд хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалтын төсөлд тусгах санал боловсруулж яамны ТЗДТБХЗГ-т хүргүүлэх;

2. Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2018 онд байгуулах үр дүнгийн гэрээний төслийн 1.1.2-т тусгагдсан “Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэх, дугаар олгох журмыг шинэчлэн боловсруулж батлах” арга хэмжээг III сарын ажлын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх;

Технологи, мэдээлэл, сургалт, судалгааны хэлтэст

3. Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, суурь бүтэц, салбар замын мэдээллийн сан төвлөрүүлэх програм хангамжийн ажлын даалгаврыг програм хангамж зохиомжлох байгууллагуудад хүргүүлж үнийн санал авах, батлагдсан төсвийн хүрээнд ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажиллах;

4. Төвийн цахим хуудсыг шинэчлэх, цахим хуудсанд хандах хандалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх, ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийг хангах;

5. “О+Р 941 санамж, Гост 33435-2015, Гост Р 54115-2010 стандартын төслийн орчуулгыг төмөр замын мэргэжлийн ажилтнаар хянуулах;

Захиргаа, санхүүгийн хэлтэст

6. Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүнд ЗТХЯ-наас Л.Булганхүү, Т.Уянга, мөн Монгол Улсын “Зөвлөх инженер” А.Батболд, “УБТЗ” ХНН-ээс ТЗБА-ны орлогч дарга, ерөнхий инженер Л.Энхболд, “БТЕГ” ХХК-ийн Хөдөлгөөний албаны дарга Б.Баяржаргал нар багтсан бөгөөд зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулж буйтай холбогдуулан зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах албан тушаалтны нэр ирүүлэх тухай албан бичгийг ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ, төмөр замын байгууллагуудад хүргүүлж санал авч бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах;

7. Төвийн захирлын 2018 оны А/09 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал, хөдөлмөрийн гэрээ дүгнэх шалгуур үзүүлэлтийн төслийг төвийн Захиралд танилцуулж шийдвэрлүүлэх;

8. “... харьяа байгууллагын тогтмол гаргах тайлан, мэдээллийн нэр төрөл, хугацаа”-ны 3.12-т заасан худалдан авах ажиллагааны тайланг 03 дугаар сарын 25-ны дотор, 4.17-д заасан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл /ЗТХЯ-наас албан бичиг ирсэн тохиолдолд/ 03 дугаар сарын 15-ны дотор ЗТХЯ-ны БТГ-т хүргүүлж тайлагнах;

9. ЗТХЯ-ны ТЗУГ-ын 2018.01.08-ны 05/87 тоот албан бичгээр ирсэн ЗТХ-ийн сайдын 2018 оны “Зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 05 дугаар тушаалын биелэлтийг ЗТХЯ-нд хүргүүлж тайлагнах;

10. Засгийн газрын 2017 оны “...Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” 337 дугаар тогтоолын 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлж ажиллах;

11. ЗТХ-ийн сайдын 2018.01.23-ны 01/355 тоот албан бичиг, Сайдын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 02 дугаар албан даалгаврын мөрөөр авч хэрэгжүүлсэн тайлан мэдээллийг 03 дугаар сарын 25-ны дотор ЗТХЯ-ны ТЗУГ-т хүргүүлж тайлагнах;

Нийтлэг:

12. Нэгжүүдийн хэмжээнд хэрэгжилт удаашралтай 10 (ЗСХ–5, ТМССХ–3, ХЗХБХ–2) 10 арга хэмжээ байгаад анхаарч гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт буюу хүрэх үр дүнд бүрэн хүргэхэд чиглэсэн төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

13. Хөдөлмөрийн дотоод журмын 6.2.3-т заасны дагуу нэгжийн сарын ажлын бичмэл тайлан, төлөвлөгөөний биелэлтийг цаг тухайд нь төвийн Захиралд танилцуулж байх.

ХЯНАСАН:

“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗАХИРАЛ

Т.АРИУНБААТАР

ЗӨВШӨӨРСӨН:

ХЗХБХ-ИЙН ДАРГА

М.БАТМЯГМАР

ТМССХ-ИЙН ДАРГА

Б.ЭНХЖАРГАЛ

ЗСХ-ИЙН ДАРГА

Н.ШИНЭБАЯР

БОЛОВСРУУЛСАН:
ХШҮДАХА

Э.ОСОРЖАМАА